ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 07 өдөр Дугаар 6/95 Бор-өндөр сум

Үйлчлэгч Б.Уранчимэгийг
үүрэгт ажлаас нь чөлөөлж, хэвтэн эмчлүүлэхийн үйлчлэгчээр
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 50 дугаар зүйлийн 50.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 2023 оны "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" 240 тоот тогтоолын 6 дугаар хавсралт, "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 241 тоот тогтоолын 10 дугаар хавсралт, 2022 оны "Журамд өөрчлөлт оруулах тухай" 491 тоот тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2018 оны "Эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчдын хоол унааны хөнгөлөлт, нэмэгдэл, урамшлын хэмжээг тогтоох тухай" А/548 тоот тушаал, 2020 оны "Хамтын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах тухай" А/69 дугаар тушаал, тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Мэс заслын тасгийн үйлчлэгч Батсайханы Уранчимэг нь өөрийн хүсэлтээр хэвтэн эмчлүүлэх тасгийн үйлчлэгчээр ажиллах хүсэлт гаргасан тул 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2. Б.Уранчимэгийн ажлыг хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга	Д.Боргил	Өмч хамгаалах комиссын гишүүн
Гишүүд	Г.Мөнгөнцэцэг	Хэвтэн эмчлүүлэх тасгийн үйлчлэгч
С.Рагчаасүх	Архив, бичиг хэргийн ажилтны хавсран гүйцэтгэгч	

3. Б.Уранчимэгийг 2023 оны 12 дугаар сарын 07-ний өдрөөс хэвтэн эмчлүүлэх тасгийн үйлчлэгчээр томилон ТҮ1 шатлалаар тогтоон үндсэн цалинг 750.000 (долоон зуун тавин мянга), хоолны мөнгө өдрийн 3000 (гурван мянга), төрийн алба хаасан хугацааны нэмэдэл 4% 30.000 (гучин мянга) төгрөгөөр тус тус тооцож олгохыг Нягтлан бодогч (Т.Эрдэнэболор)-д зөвшөөрсүгэй.

4. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ёс зүйн хэм хэмжээг мөрдөн ажиллахыг Б.Уранчимэгт үүрэг болгосугай.

ДАРГА А.БАТБААТАР

1820060013
ХТУ3246 ТБАГУТУГ 9075615